



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 10 өдөр

Дугаар А/244

Сүхбаатар сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.5 "а", Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 17 дугаар зүйлийн 17.1, Засгийн газрын 2018 оны 354 дугаар тогтоол "Олон Упсын хүүхдийн спортын наадмын тухай" 2018 оны 183 дугаар тогтоол "Улсын хэмжээнд спортын наадам зохион байгуулах тухай журам", Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/777 дугаар тушаал "Спортын наадам зохион байгуулах тухай", аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2019 оны 09 дүгээр сарын 09-15-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдах Монголын Хүүхдийн спортын VI наадамд аймгийн өсвөр үеийн баг тамирчдыг удирдамжийн дагуу бэлтгэл сургуулилтад хяналт тавьж хангуулан оролцуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Нарантуяа

-Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

У.Батменх

-Аймгийн Биеийн тамир спортын газрын дарга

Гишүүд:

Б.Энхбат

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

О.Мөнхбаяр

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ч.Жаргалсайхан

-Аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга

П.Оюун

-Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

Э.Оюун-Эрдэнэ

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

О.Наранбаатар

-Аймгийн Спортын бүрэн дунд сургуулийн захирал

С.Дашдаваа

Аймгийн Биеийн тамир спортын газрын ахлах мэргэжилтэн

2.Спортын наадмын тогтоосон хугацаанд баг тамирчдыг бэлтгэл, сургуулилтыг чанарын өндөр түвшинд хангуулахыг Спортын холбоодод, тамирчдын бэлтгэл сургуулилтын хуваарь, удирдамж, зааврын дагуу хяналт тавьж, зохион байгуулан оролцуулахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын орлогч /Б.Нарантуяа/-д даалгасгай.

ЗАСАГ ДАРГА



Ш. ОРГИЛ